

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	1
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл	1
1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт	1
1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт	2
1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт	2
1.2.1 Ордын нөөц	2
1.2.2 Ордын уул техникийн нөхцөл болон ашиглалтын системийн сонголт	3
1.3 Уурхайн тоног төхөөрөмж	3
1.3.1 Уулын үндсэн техник, тоног төхөөрөмж	3
1.4 Дэд бүтэц	3
1.4.1 Уурхайн барилга байгууламж	3
1.4.2 Цахилгаан хангамж	4
1.4.3 Дулаан хангамж	4
1.4.4 Усан хангамж	4
1.5 Төслийн эцсийн бүтээгдэхүүн	4
1.5.1 Элементийн шинжилгээ, металлын баланс	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
2.1 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	8
3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ11	11
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 20	20
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
13.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
14.	ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ажиллах хүч	2
Хүснэгт 2. Алс хайлуур жоншны ордын урд хэсгийн нөөцийн нэгдсэн хүснэгт	3
Хүснэгт 3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц	3
Хүснэгт 4. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж	3
Хүснэгт 5. Эскаваторын техникийн үзүүлэлт	4
Хүснэгт 6. Хөрс хуулалт болон олборлолтод ажиллах Hyundai 320 LC-3 эскаваторын бүтээл, хэрэгцээний тооцоо	5
Хүснэгт 7. Тээврийн зай	6
Хүснэгт 8. Howo автосамосвалын техникийн үзүүлэлт	6
Хүснэгт 9. Автосамосвалын, бүтээл хэрэгцээний тооцоо	6
Хүснэгт 10. Shantui SD16 маркийн бульдозерын техникийн үзүүлэлт	8
Хүснэгт 11. Бульдозерын бүтээл, хэрэгцээний тооцоо	8
Хүснэгт 12. Ил уурхайн зохиомжлолд тусгасан хэмжээс	10
Хүснэгт 13. Ил уурхайн жонш олборлолтын календарьчилсан төлөвлөлт	10
Хүснэгт 14. Хөрсний овоолгын хэмжээс	11
Хүснэгт 15. Хуулах шимт хөрсний хэмжээ	11
Хүснэгт 16. Усны хэрэглээ	12
Хүснэгт 17. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	18
Хүснэгт 18. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 19. Суулгах модны хэмжээ, зардал	24
Хүснэгт 20. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
Хүснэгт 23. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
Хүснэгт 24. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг	1
--	---

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1.Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

Төслийн нэр :	“Өлзийт ухаа” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах
Төсөл хэрэгжүүлэгч :	“Хас рич” ХХК 5226902 Тоот регистрийн дугаартай
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 28-р хороо, 51-р байр, 10 тоот

Үндсэн үйл ажиллагаа. “Хас рич” ХХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээгээр 7490 кодтой “Ашигт малтмал ашиглах” үндсэн үйл ажиллагаатай.

Төсөл хэрэгжүүлэгч “Хас рич” ХХК 500.01 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV-018971 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд Өлзийт ухаа хайлуур жоншны ордыг эзэмшиж байгаа бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2045 он хүртэл хүчинтэй байна.

1.1.2.Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт

“Хас рич” ХХК-ийн Өлзийт ухаа хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Чойр хотоос зүүн урагш 59 км зайд, байр зүйн зургийн L-49-62-Г хавтгайд MV- 018971 тоот “Өлзийт ухаагийн” хайлуур жоншны орд оршино. Улаанбаатар хотоос 290 км хатуу хучилттай засмал замтай, төмөр замын 20-р зөрлөгөөс 400-500 м зайд байрладаг.



Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршилын зураг

1.1.3. Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

Төслийн удирдлагын нэгж. Хүний нөөцийн менежментийн хувьд компанийн өөрийн ажиллагсдын үйл ажиллагааг төв оффисоос удирдаж ажиллах бөгөөд хүний нөөцийн удирдлага нь уурхайн ажиллагсдыг сонгон авч, удирдлага ажилтны хоорондох гүүр болж ажиллана.

Компанийн үйл ажиллагааны өдөр тутмын шийдвэр гаргалтыг ерөнхий захирлын алба болох чиг үүрэг хариуцсан бүтэц уурхай дарга, ашиглалт хариуцсан ерөнхий инженер, хангамжийн алба, санхүүгийн хэлтэс, үйлчилгээний хэсэг, хүний нөөцийн алба зэргээс бүрдэнэ.

Төсөлд шаардлагатай хүний нөөц. “Хас рич” ХХК-ний жонш баяжуулах үйлдвэр болон уурхайн удирдлагын бүтэц дараах дарааллаар явагдана. Үүнд:

Өлзийт ухаагийн жоншны төслийн ажиллах хүчний тооцоог хэсэг, нэгж тус бүрд техник, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулан мэргэжлийн түвшин бүрээр тооцоолсон. Төслөөр нийтдээ 145 ажлын байр бий болох юм. Уурхайн горим ёсоор жилд ил, далд уурхайн 300 хоног, флоатацийн баяжуулах үйлдвэрийн хэсэг 212 хоног ажиллана.байна.

Төслийн нэгжийн ажлын горим. Ил уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй ажиллана. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цагаар ажиллана. Дараах хүснэгтэд ил уурхайн ажиллах горим, ээлжийн зохион байгуулалтыг харуулав.

Хүснэгт 1. Ажиллах хүч

Үзүүлэлт	Нэгж	ТЭЗҮ-ээр төлөвлөгдсөн	2026 онд ажиллах
Хуанлийн хоног	өдөр	365	365
Баяр ёслол тооцсон хоног	өдөр	8	6
Цаг агаарын хүнд нөхцөл тооцсон хоног	өдөр	30	15
Бусад	өдөр	27	74
Жилийн ажлын өдөр	өдөр	300	270
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10	10
Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2	2
Ээлжийн цаг ашиглалт			
Ажлын наряд авах цаг	мин	20	20
Хоолны цаг	мин	60	60
Ээлж хүлээлцэх хугацаа	мин	20	20
Бусад	мин	10	10
Ээлжин дэх сул зогсолт	мин	110	110
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10.0	10.0
Ээлжийн цэвэр ажиллах цаг	цаг	8.2	8.2
Ээлжийн цаг ашиглалт	%	82%	82%
Жилд ажиллах цэвэр ажлын цаг	цаг/жил	4,900	817

1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

1.2.1. Ордын нөөц

Өлзийт-Ухаагийн хайлуур жоншны ордын хэмжээнд судал – 1, 2, 3 болон метасоматит хүдрийн биет – 1, 2-ийн хэмжээнд хайгуулын ажил гүйцэтгэж нөөц бодсон. Судлууд дээр тухайн судлын онцлогоос хамааруулан 25-80 м зайтай сувгуудыг малтсан бол хайгуулын шугам хоорондын зайг 37-80 м зайтай сонгон авч өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн. Судал- 1 дээр зөвхөн I горизонтод өрөмдөж нөөцийг С зэргээр бэлдсэн бол, 2-р судал дээр хайгуулын шугамуудыг нягт байрлуулж I-IV горизонтод өрөмдөж нөөцийг В+С зэргээр бодсон. 3-р судал дээр I, II горизонтод өрөмдөж нөөцийг В+С зэргээр тооцож гаргасан.

Өлзийт-Ухаагийн хайлуур жоншны ордын Өлзийт нэртэй MV-018971 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн нөөц бодитой (В) зэргээр 122,947.90 тн хүдэрт, 41.58 %-ийн дундаж агуулгатай 51,123.06 тн СаF₂, хайлуур жоншны хүдрийн боломжтой (С) нөөцийг 293,294.05 тн “ХАС РИЧ” ХХК

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

хүдэрт, 42.93 %-ийн дундаж агуулгатай 125,910.56 тн СаF₂, хайлуур жоншны хүдрийн бодитой болон боломжтой (B+C) нөөцийг 416,241.95 тн-оор, 42.53 %ийн дундаж агуулгатай хайлуур жоншны бодитой болон боломжтой (B+C) нөөц 177,033.62 тн СаF₂ хүлээн авч II бүлгийн ордод хамааруулан Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

Хүснэгт 2. Алс хайлуур жоншны ордын урд хэсгийн нөөцийн нэгдсэн хүснэгт

№	Үндсэн үзүүлэлтүүд						
	Судлын биетийн дугаар	Нөөцийн зэрэг	Хүдрийн хэмжээ, м3	Хүдрийн биетийн дундаж Агуулга, %	Эзлэхүүн жин, /тн/м ³ /	Хүдрийн нөөц, /тн/	СаF ₂ -ын нөөц, /тн/
1	Судал-1	C	16,309.58	50.55	2.6	42,404.9	21,435.3
		B+C	16,309.58	50.55	2.6	42,404.9	21,435.3
2	Судал-2	B	45,298.57	41.7	2.6	117,776.3	49,064.7
		C	58,881.02	41.2	2.6	153,090.6	63,056.7
		B+C	104,179.59	41.4	2.6	270,866.9	112,121.4
3	Судал-3	B	1,989.08	39.8	2.6	5,171.6	2,058.3
		C	18,514.97	54.2	2.6	48,138.9	26,088.5
		B+C	20,504.05	52.8	2.6	53,310.5	28,146.8
4	ХБ1С-1	C	6,593.99	33.3	2.6	17,144.4	5,703.9
5	ХБ2С-1	C	12,505.84	29.6	2.6	32,515.2	9,627.7
6	Ордын хэмжээнд	B	47,287.65	41.6	2.6	122,947.90	51,123.06
		C	112,805.40	42.9	2.6	293,294.04	125,910.54
		B+C	160,093.05	42.5	2.6	416,241.93	177,033.62

1.2.2.Ордын уул техникийн нөхцөл болон ашиглалтын системийн сонголт

Ордын уул техникийн нөхцөл, ашиглах аргууд, хэтийн төлөв байдал зэргээс хамааруулж ил уурхайд авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр уулын ажлыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Сийрэгжүүлэлт Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
	Олборлолт	Сийрэгжүүлэлт Ухаж ачих Тээвэрлэх Агуулахад хураах

1.3 Уурхайн тоног төхөөрөмж

1.3.1.Уулын үндсэн техник, тоног төхөөрөмж

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг тус ил уурхайн талбай дээр байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Мөн шаардлагатай техник тоног төхөөрөмжийг нэмж авна. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

Хүснэгт 4. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмжийн марк
Автосамосвал	Howo -7
Экскаватор	HYUNDAI R320LC-3
перфераторын иж бүрдэл	MZ7665
Өөрөө ачигч буулгагч машин	XYWJ-2
Компрессор	7BKM-25/8
Утгуурт ачигч	ZL800
Гар өрмийн машин	YT-28

Экскаваторын сонголт: Уурхайд ажиллуулах тоног төхөөрөмжийн сонголтыг захиалагч байгууллагын санал болгосон хүчин чадлаар уурхайг ашиглахад хөрс болон хүдэрт 1.4 м3 шанаганы багтаамжтай экскаватор шаардлагатай байна.

Экскаваторын техникийн үзүүлэлт, үнэ, ашиглалтын гол зардал, хүчин чадал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн эдийн засгийн харьцуулалт хийх аргаар сонголт хийв.

Сонгосон экскаватор нь хөрөнгө оруулалтаар бага (захиалагчийн үнийн санал) болон бусад үзүүлэлтүүдээр зөрүү багатай, амьдрал дээр сэлбэг нийлүүлэлт, үйлчилгээний ажил хурдан, шуурхай байгаа зэрэг давуу талуудыг харгалзан тус уурхайд HYUNDAI R320LC-3 загварын экскаватор ажиллуулахаар сонгон авч төсөлд тусгав.

Хүснэгт 5. Экскаваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо хэмжээ	Hyundai 320 LC-3
1	Утгуурын багтаамж	м3	1.44	
2	Утгалтын хамгийн их радиус	м	11.25	
3	Утгалтын хамгийн их гүн	м	7.5	
4	Ачих хамгийн их өндөр	м	7.75	
5	Явах хамгийн их хурд	км/цаг	4.0	
6	Арын эргэлтийн радиус	м	4.78	
6	Явах ангийн өргөн	м	3.5	
7	Урт	м	6.5	
8	Өргөн	м	3.5	
9	Өндөр	м	3.5	
10	Хөдөлгүүрийн чадал	кВт	193	
11	Жин	тн	32.2	
12	Түлшний савны багтаамж	л	610	

Экскаваторын ажлын цагийн бүтээл (м³/цаг):

$$Q_{эц} = \frac{3600 * E * K_{уд} * K_{эт} * K_{б} * K_{м} * K_{оу}}{t_{эм} * K_{с}}$$

Энд:

- E – утгуурын багтаамж, м³
- K_{уд} – утгуур дүүргэлтийн коэффициент
- K_{эт} – экскаваторын төрлийг тооцох коэффициент
- K_б – техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент
- K_м – мөргөцгийн нөхцөл тооцох коэффициент
- K_{оу} – операторын ур чадвар тооцох коэффициент
- t_{эм} – циклийн хугацаа, сек

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- K_c – сийрэгжилтийн коэффициент

Экскаваторын ажлын ээлжийн бүтээл ($m^3/ээлж$):

$$Q_{ээ} = Q_{эц} * T_{э} * K_{эц} * K_{ма} * K_{тх}$$

Энд:

- $T_{э}$ – ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг
- $K_{эц}$ – цаг ашиглалтын коэффициент
- $K_{ма}$ – мөргөцөг дэх ахилт шилжилтийг тооцох коэффициент
- $K_{тх}$ – экскаваторыг тээврээр хангах нөхцөлийг тооцох коэффициент

Хүснэгт 6.. Хөрс хуулалт болон олборлолтод ажиллах Hyundai 320 LC-3 экскаваторын бүтээл, хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2026 он	
			Хөрс	Хүдэр
Тооцооны үзүүлэлт				
1	Экскаваторын утгуурын багтаамж, Е	м3	1.44	1.44
2	Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м ³	2.60	2.60
3	Утгуур дүүргэлтийн коэффициент	-	0.95	0.95
4	Мөргөцгийн нөхцөл тооцох коэффициент	-	0.87	0.87
5	Экскаваторын төрлийг тооцох коэффициент	-	0.9	0.9
6	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.1	1.1
7	Экскаваторын мөчлөгийн хугацаа	сек	37	50
Бүтээлийн тооцоо				
8	Экскаваторын цагийн бүтээл	м ³ /цаг	94.7	70.8
		тн/цаг	246.3	184.1
9	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.82	0.82
10	Мөргөц дэх ахилт шилжилт тооцох коэффициент	-	0.85	0.85
11	Экскаваторын төрлийг тооцох коэффициент	-	0.8	0.8
12	Экскаваторын ээлжийн бүтээл	м ³ /ээлж	526.2	393.3
		тн/ээлж	1,368.0	1,022.5
14	Экскаваторын хоногийн бүтээл	м ³ /хон	526.2	393.3
		тн/хон	1,368.0	1,022.5
15	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент	-	0.7	0.7
16	Экскаваторын жилийн бүтээл	мян.м ³ /жил	110.5	82.6
		мян.тн/жил	287.3	214.7
17	Уурхайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ	мян.м ³ /жил	22.6	3.5
18	Экскаваторын тооцооны тоо	шир	0.2	0.0
19	Нийт экскаваторын жилд ажиллах цаг	мото.цаг	1,002	205
20	Шаардлагатай экскаваторын тоо	шир	1.0	1.0

Уурхайд 1 ширхэг Hyundai 320 LC-3 маркийн экскаватор байхад хүчин чадлыг хангаж ажиллахаар байна.

Тээвэрлэх процесс

Өлзийт ухаа хайлуур жоншны ордын хүдэр олборлолтод экскаватор автосамосвалын хослол ашиглах ба автосамосвалууд нь ил уурхайгаас олборлох хүдрийг уурхайн замаар тээвэрлэж бутлах хэсэг, түр овоолго хүртэл 321.9-342.57 м, хоосон чулуулгийг хөрсний гадаад овоолго хүртэл 300-500 м зайд тээвэрлэн хураана.

Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн 25 тн-ийн даацтай HOWO загварын автосамосвал

“ХАС РИЧ” ХХК

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ашиглахаар төлөвлөсөн. Автосамосвалын хөрс, хүдэр тээвэрлэх зайг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Тээврийн зай

Үзүүлэлт	Нэгж	2026 он
Хүдэр тээврийн дундаж зай	м	320
Хөрс тээврийн дундаж зай	м	460

Хүснэгт 8. Нowo автосамосвалын техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Нэгж	Утга
Хөдөлгүүрийн чадал	м.хүч	290
Хамгийн их хурд	км/цаг	75
Тэвшний багтаамж	м ³	13-16
Даац	тн	25
Дугуйн харьцаа		6х4
Өөрийн масс	тн	12.5
Эргэлтийн радиус	м	10.2
Урт	м	8.47
Өргөн	м	2.49
Өндөр	м	2.95
Дугуйн тоо	ш	10
Түлшний савны багтаамж	литр	336

Автосамосвалын бүтээлийн тооцоо (м³/ээлж):

$$Q_{аз} = \frac{3600 \cdot V_T \cdot K_{эи} \cdot K_{тб} \cdot K_{ба} \cdot K_{оу} \cdot K_N \cdot K_{ца} \cdot T_э}{T_p}; (4.5.4 - 1)$$

Энд:

- V_T – Тэвшний багтаамж багтаамж, м³
- $K_{эи}$ – Экскавацлалтын итгэлцүүр
- $K_{тб}$ – Тэвшний багтаамж ашиглалтын итгэлцүүр
- $K_{бу}$ – Автосамосвалын бэлэн байдлыг тооцох итгэлцүүр
- $K_{оу}$ – Операторын ур чадварын итгэлцүүр
- K_N – Замын нөхцөл тооцсон итгэлцүүр
- $K_{ца}$ – Цаг ашиглалтын итгэлцүүр
- $T_э$ – Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг
- T_p – Рейсийн хугацаа, сек

Автосамосвалын рейсийн хугацаа (сек):

$$T_p = t_a + t_{хө} + t_б + t_{сэ}; (4.5.4 - 2)$$

Энд:

- t_a – автосамосвалыг ачаалах хугацаа, сек
- $t_{хө}$ – автосамосвалын хөдөлгөөний хугацаа, сек
- $t_б$ – ачаа буулгах хугацаа, сек

Хүснэгт 9. Автосамосвалын, бүтээл хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2026 он	
			Хөрс	Хүдэр
Утгуур дахь ачааны хэмжээ				
1	Экскаваторын утгуурын багтаамж, Е	м3	1.44	1.44
2	Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м ³	2.60	2.60

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Утгуур дүүргэлтийн коэффициент	-	0.95	0.95
4	Чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.1	1.1
5	Тэвшин дэх чулуулгийн овоололт тооцох коэффициент	-	1.1	1.1
6	1 удаагийн утгалтаар ачих чулуулгийн хэмжээ	м3	1.4	1.4
		тн	3.2	3.2
Циклийн хугацаа				
1	Утгалтын тоо /даац ашиглалтын нөхцөлөөр/	удаа	7.0	7.0
2	Экскаваторын мөчлөгийн хугацаа	сек	37	49.5
3	Экскаваторын ачаалах хугацаа	мин	4.32	5.78
4	Хоосон чиглэл дэх автосамосвалын хурд	км/цаг	40	40
5	Ачаатай чиглэл дэх автосамосвалын хурд	км/цаг	25	25
6	Тээврийн хугацаа /хоосон чиглэлд/	мин	0.7	0.5
7	Тээврийн хугацаа /ачаатай чиглэлд/	мин	1.1	0.8
8	Хурд өөрчлөлтийг тооцох коэффициент	-	1.1	1.1
9	Хөдөлгөөний хугацаа	мин	2.0	1.4
10	Автосамосвалын ачаа буулгах хугацаа	мин	0.8	0.8
11	Автосамосвалын сэлгээ хийх хугацаа	мин	1.5	1.5
12	Ачих буулгах үеийн хүлээх хугацаа	мин	1.5	1.5
13	Автосамосвалын циклийн хугацаа	мин	10.1	11.0
Цагийн бүтээл				
8	Автосамосвалын бодит даац	тн	22.6	22.6
10	1 цагт хийх рейсийн тоо	-	6.0	5.5
12	Автосамосвалын цагийн бүтээл	тн/цаг	134.8	124.0
		м ³ /цаг	51.8	47.7
Ээлжийн болон хоногийн бүтээлийн тооцоо				
13	Ээлжийн үргэлжлэх цаг	цаг	12	12
14	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.82	0.82
16	Автосамосвалын ээлжийн бүтээл	тн/ээлж	1,321.0	1,214.8
		м ³ /ээлж	508.1	467.2
17	Хоногт ажиллах ээлжийн тоо	удаа	1	1
18	Автосамосвалын хоногийн бүтээл	тн/хон	1,321.0	1,214.8
		м ³ /хон	508.1	467.2
Жилийн бүтээлийн тооцоо				
19	Жилийн календарийн хоног	хоног	365	365
20	Баяр ёслол, цаг агаарын саатлыг тооцсон зайлшгүй сул зогсох хоног	хоног	65	65
21	Жилийн ажлын хоног	хоног	300	300
22	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент	-	0.75	0.75
23	Автосамосвалын жилийн бүтээл	мян.тн/жил	297.2	273.3
		мян.м ³ /жил	114.3	105.1
24	Уурхайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ	мян.м ³ /жил	22.6	3.5
25	Экскаваторын тооцооны тоо	шир	0.20	0.03
26	Нийт экскаваторын жилд ажиллах цаг	мото.цаг	968	161
27	Шаардлагатай экскаваторын тоо	шир	1.0	1.0

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Уурхайд 25 тн даацтай Howo290 маркийн автосамосвалууд 2 ширхэг байхад уурхайн бүтээлийг хангахад хүрэлцээтэй байна.

Овоолох процесс

2026 оны олборлолтын жилд овоолго дээр хийх ажлын хэмжээ 11.3 мян.м³, шимт хөрс хуулах, зам талбай, ул цэвэрлэгээ гэх мэт туслах ажлын хэмжээ 26.9 мян.м³, нийт ажлын хэмжээ 38.2 мян.м³ байхаар төлөвлөгдөж байна.

Авто тээвэртэй гадаад овоолго үүсгэх бөгөөд үлдэц асгацын хэмжээг 50% байхаар тооцсон. Овоолгын ажилд Shantui SD16 маркийн бульдозер 1 ш ажиллах хөрсний овоолгод ажиллах бульдозерын техникийн үзүүлэлт болон бүтээлийг дараах хүснэгтүүдэд үзүүлээ.

Хүснэгт 10.. Shantui SD16 маркийн бульдозерын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Х.н	SD-16
1	Хөдөлгүүрийн чадал	кВт	131
2	Масс	тн	17
3	Хусуурын хамах чадвар	м ³	4.5
4	Хусуурын урт	м	3.38
5	Хусуурын өндөр	м	1.3
6	Ухах гүн	м	0.54
7	Хөдөлгөөний хурд, хойшоо/урагшаа	км/цаг	7.59
8	Шатахууны савны багтаамж	л	310
9	Бульдозерын өргөн	м	3.38
10	Бульдозерын урт	м	5.4
11	Бульдозерын өндөр	м	3.03



Хүснэгт 11.. Бульдозерын бүтээл, хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Нэгж	2026 он
1	Түрэгдэх чулуулгийн хэмжээ	м ³	4.5
2	Хусуурын өндөр	м	1.300
3	Хусуурын урт	м	4.50
4	Огтлох налуу	град	2.0
5	Чулуулгийн алдагдал тооцсон коэффициент	-	0.95
6	Хутга зоогдох гүн	м	0.5
7	Хутга өргөх өндөр	м	0.4
8	Хутга дүүргэх зай	м	1.7
9	Ачаатай явах зай	м	8.0
10	Ачаа тараах зай	м	2.4
11	Циклийн хугацаа	сек	34.4
12	Хутга дүүргэх хугацаа	сек	2.1
13	Ачаатай явах хугацаа	сек	6.7
14	Ачаагаа тараах хугацаа	сек	2.0
15	Хоосон буцах хугацаа	сек	8.6
16	Маневрлах хугацаа	сек	15.0
17	Хутга дүүргэх хурд	м/сек	0.8
18	Ачаатай түрэх хурд	м/сек	1.2
19	Хоосон буцах хурд	м/сек	1.4
20	Хутга дүүргэлтийн коэффициент	-	0.9
21	Сийрэгжилт тооцох коэффициент	-	1.10
22	Операторын ур чадварыг тооцох коэффициент	-	0.9
23	Цагийн бүтээл	м ³ /цаг	330
24	Ээлжийн цаг ашиглалт	-	0.82

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

25	Ээлжийн бүтээл	м ³ /ээлж	2,697
26	Хоногийн бүтээл	м ³ /хон	2,697
27	Техникийн бэлэн байдлын коэффициент	-	0.80
28	Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м ³	2.60
29	Жилийн бүтээл	мян.м ³ /жил	647.3
		мян.тн/жил	1,683.1
30	Жилд хийх уулын ажлын хэмжээ	мян.м ³ /жил	11.3
31	Жилд хийх туслах ажлын хэмжээ /зам, талбай, ул цэвэрлэгээ, шимт хөрс хуулалт/	мян.м ³ /жил	26.9
32	Жилд хийх нийт уулын ажлын хэмжээ	мян.м ³ /жил	38.2
33	Шаардлагатай бульдозерын тооцооны тоо	шир	0.1
34	Шаардлагатай бульдозерын тоо	шир	1
35	Жилд ажиллах цаг	мото.цаг/жил	288.9

Бульдозерын жилийн бүтээл 647.3 мян.м³ байгаа бөгөөд уурхайн гадаад овоолго болон бусад туслах ажлыг хийхэд, 1 ширхэг байхад уурхайн хүчин чадлыг хангаж ажиллахаар байна.

1.4. Баяжуулалтын технологи

Өлзийт ухаа хайлуур жоншны ордын дээжид технологийн туршилтын ажлыг 2014 онд “МАК” ХХК-ийн технологийн судалгааны төв гүйцэтгэсэн байна. Технологийн туршилтыг СаF2-20.52%, СаСО3-1.08% агуулгатай, 252.7 кг жинтэй дээжид хийж гүйцэтгэсэн байна. Уг ТЭЗҮ-ийг дээр технологийн туршилт дээр үндэслэж хийсэн ба цаашид захиалагч байгууллага нийлүүлэх тоног төхөөрөмж болон олборлолтын явцад хүдрийн дээж дээр дахин технологийн туршилт хийлгэх шаардлагатайг зөвлөмж болгож байна.

Хүдэр баяжуулах технологийн туршилтын үр дүн

Өлзийт ухаа ордын дээжид хийсэн технологийн туршилтын судалгааны үр дүнг доор үзүүлээ. Үүнд:

- Энэхүү ордын хүдрийн сийрэг нягт 1.82 гр/см³ байсан байна.
- Бүхэллэг хүдрийн эзлэхүүн жин дунджаар 2.60 гр/см³ байсан байна.
- Үндсэн флотацийн зохистой горим тогтоох туршилтаар үндсэн флотацид:
 - -0.074 мм-ын агуулга 65%
 - Урвалын орчин рН=9.0-9.5
 - Дарагч урвалжийн (шингэн шил) зарцуулалт-250 гр/тн
 - Цуглуулагч урвалжийн (ЖКТМ) зарцуулалт-400 гр/тн гэж тогтоосон байна.
- Задгай схемийн туршилтаар баяжмал дахь жоншны агуулга-94.83%, баяжмалын гарц-9.55%, Авалт-82.62% байсан.

1.4.1. Хүдэр баяжуулах технологи

Технологийн туршилтын үр дүнд үндэслэн хайлуур жоншны хүдрийн хөвүүлэн баяжуулах аргаар баяжуулах нь тохиромжтой байгаа ба тус технологийн туршилтын үр дүнд үндэслэн хүдрийн баяжуулах үйлдвэрийг 2026 онд барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2026 онд баяжуулах үйлдвэрийг барьж байгуулснаар 2026 оноос ил уурхай болон далд уурхайгаас олборлосон хайлуур жоншны хүдрийн баяжуулан 94.83% агуулгатай хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэнэ. 2026 онд олборлосон СаF2-ийн 38.43%-ийн агуулгатай, 9.15 мян.тн хайлуур жоншны хүдрийг хүдэр баяжуулах үйлдвэр, бутлах цехийн хүдэр хүлээн авах талбайд овоолохоор төлөвлөсөө.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Иймд 2026 онд хүдэр баяжуулах үйл ажиллагаа болон баяжмал гарган авах болон борлуулах үйл ажиллагаа хийгдэхээргүй төлөвлөж байна

1.5. Ил уурхайн төлөвлөлт

Өлзийт ухаа хайлуур жоншны ордын ил уурхай нь бодитой /В/ нөөцийг хамарч 2026 онд ашиглах ил уурхайн нь 1270 м түвшин хүртэл үүснэ. Ил уурхайн төсөл зохиомжийн Surpac программыг ашиглан гүйцэтгэсэн.

Хүснэгт 12. Ил уурхайн зохиомжлолд тусгасан хэмжээс

Үзүүлэлт	Нэгж	Хэмжээс
Ил уурхайн ажлын доголын өндөр	м	5
Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	10
Ажлын доголын хажуугийн өнцөг	град	55-65
Ажлын бус доголын хажуугийн өнцөг	град	65-70
Ажлын талбайн өргөн	м	18
Доголын налуу траншейн өргөн	м	10
Налуу траншейн дагуу налуу	0/00	80
Доголын аюулгүйн бермийн өргөн	м	3
Гадаад доголоор нээх траншейн тоо	ш	1
Уурхайн амсрын ерөнхий урт	м	160
Уурхайн амсрын өргөн	м	75

Ил уурхайн хайлуур жоншны хүдэр олборлолтын календарьчилсан төлөвлөлт

2026 оны ашиглалтын жил дуусахад 9-12-р сар хүртэл нийт ажлын цэвэр 100 хоног үлдэж байна. Иймд 2026 онд олборлох хайлуур жоншны хүдрийн хэмжээ 9,000 тн байна. Доорх хүснэгтэд ил уурхайн 2026 оны календарьчилсан төлөвлөлтийг сар бүрээр тооцон харуулав.

Хүснэгт 13. Ил уурхайн жонши олборлолтын календарьчилсан төлөвлөлт

Үзүүлэлт	Нэгж	Ашиглалтын сар							Нийт 2026 он
		4	5	6	7	8	9	10	
2026 оны олборлолт									
Жонш олборлолт	мян.тн	1.3	1.3	1.3	1.3	1.3	1.3	1.3	9.15
Дундаж агуулга, CAF2	%	41.35	41.35	41.35	41.35	41.35	41.35	41.35	41.35
Жоншны нөөц	мян.тн	0.54	0.54	0.54	0.54	0.54	0.54	0.54	3.53
Хөрс хуулалт	мян.м3	3.23	3.23	3.23	3.23	3.23	3.23	3.23	22.6
Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	2.47	2.47	2.47	2.47	2.47	2.47	2.47	2.47
Нийт уулын цул	м3	3.8	3.8	3.8	3.8	3.8	3.8	3.8	26.3
	тн	9.4	9.4	9.4	9.4	9.4	9.4	9.4	65.7

Овоолгын төлөвлөлт

Ашиглалтын нийт хугацаанд уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн ачиж автотээвэртэй захилах хэлбэрийн бульдозерийн гадаад овоолготой ашиглалтын системийг хэрэгжүүлнэ. Хөрсний овоолгын хэмжээсийг, хөрсний овоолгын байршил болон ашиглалтын нийт жил дэх хөрсний овоолгын хэмжээг дараах хүснэгтүүд болон зурагт тус тус үзүүлэв.

Хүснэгт 14. Хөрсний овоолгын хэмжээс

Үзүүлэлт	Утга
Овоолгын доголын өндөр	10 м
Овоолгын доголын хажуугийн өнцөг	29 град

Хүснэгт - 10. Хөрсний овоолгын төлөвлөлт

Үзүүлэлт	Нэгж	2026 он
Хөрс хуулалт	м3	22,590
Сийрэгжилт		1.3
Овоолгод хураагдах чулуулгийн эзлэхүүн	м3	29,367

Ил уурхайн процесс

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, хайлуур жоншны хүдэр олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Ил уурхайд дараах процессууд явагдана: Үүнд

- Шимт хөрс хуулалт
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Ухаж ачих
- Тээвэрлэх
- Овоолох

Шимт хөрс хуулалт

Ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.3 метр зузаантайгаар урьдчилан хуулна. Шимт хөрс хуулах ажилд бульдозер ашиглах бөгөөд бульдозероор хусаж түрэн хуримтлуулан автосамосвал дугуйт ачигчийн хослолоор ачиж тээвэрлэн шимт хөрсний овоолгод байршуулна.

Хуулж бэлтгэсэн шимт хөрс нь ордын ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2 м байх бөгөөд хажуугийн өнцөг нь 25-33 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна. Шимт хөрс хуулалтын ажилд Shantui SD16 бульдозер ашиглана.

Хүснэгт 15. Хуулах шимт хөрсний хэмжээ

Д/д	Үзүүлэлт	Эвдэгдэх талбай, га	Хуулах шимт хөрсний зузаан, м	Хуулах шимт хөрсний хэмжээ, м ³
1	Ил уурхай	0.9	0.3	2,580
2	Овоолго	1.2	0.3	3,600
3	Шимт хөрс	0.3	0.3	927
4	Барилга байгууламж	5.2	0.3	15,600
5	Зам, талбай	1.5	0.3	4,647
6	Далан	0.7	0.3	2,100
	Нийт	9.8		29,454

2026 оны ил уурхайн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлаар нийт 9.8 га талбай эвдэгдэх бөгөөд нийт хуулах шимт хөрсний хэмжээ 29.4 мян.м³ байна. Хуулж бэлтгэсэн шимт хөрсийг шимт хөрсний овоолгын талбайд хураана.

1.6. Дэд бүтэц

1.4.1. Уурхайн барилга байгууламж

Уурхайн хотхон. Хас рич ХХК нь уурхайн зүүн талд орших 39.7 га талбайтай жонш баяжуулах үйлдвэрийг байгуулах үед дэд бүтцийн барилга байгууламжийг захиргаа аж ахуйн байр, цайны газар, ажилчдын байр, засварын газар, ШТС техник тоног төхөөрөмж байрлах талбай, сэлбэг хэрэгслийн агуулах зэргийг барьж байгуулан Үйлдвэр хүлээн авах Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. “Хас рич” ХХК нь баяжуулах үйлдвэрийнхээ дэд бүтцийг байгуулан уурхайн үйл ажиллагааг уялдуулан явуулна.

Тэсрэх материалын агуулах. ТМА нь ордоос баруун урд зүгт 250 м зайд байрлана. Тэсрэх материалын агуулах нь 1 га талбайд тэсрэх материалтай харьцах, хадгалах, аюулгүйн зайнуудын норм дүрмийн дагуу байрлагдсан байна. Тус агуулах нь 10 тонн багтаамжтай чингэлгийг галд тэсвэртэй материалаар доторлосон анфо, эмульсийн тэсрэх бодис, дагалдах тэсэлгээний хэрэгслийг хадгалах 1 ш агуулахаас бүрдэх бөгөөд MNS 4223:94 стандартын шаардлагыг хангасан байна. Хүдэрт 8.92 тн тэсрэх бодис тус тус хэрэглэнэ. Холбоо дохиолол Уурхайн хэмжээгээр ажлын уялдаа холбоог сайжруулахын тулд хэсэг цехүүдийн дунд богино долгионын станцуудыг ашиглана.

Сэлбэг материалын агуулах. Хуучин тоног төхөөрөмжийн сэлбэг цуглуулагчид өгөх/зарах боломжтой бол дахин ашиглах, Ашиглах боломжгүй хэсгүүдийг сэлбэг цуглуулагчид өгөх/зарах.

1.4.2. Цахилгаан хангамж

Жонш боловсруулах үйлдвэрийг Чойр-Сайншандын 110/35/6 кВ-ын 26-р зөрлөг дэд станцаас 35кВ-ын шугамаар цахилгаан эрчим хүчээр хангана. Өндөр хүчдэлийн шугамын нийт трассын урт 3.9 км үүнээс 0.45 км нь кабель шугам байна. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангахын тулд бие биеэсээ үл хамаарах 2 үчний трансформатор бүхий ЕБДС-ын схемийг сонгов.

1.4.3. Дулаан хангамж

Тусгаарлагч хамгаалалт, дулаан шаардлагатай үйлдвэрийн зориулалт бүхий барилга байгууламж зэрэг нь бат бөх, тогтвортой байх шаардлагыг хангасан, галд тэсвэртэй, удаан хугацаанд ашиглах боломжтой, түүнчлэн архитектур, эдийн засаг, дулааны техникийн нормд бүрэн нийцсэн байна. Дулааны бүх хэрэглэгчид нь үйлдвэрлэлийн байгууламжаас бүрдэнэ. Дулааны горим дахь дулааны алдагдал нь дулааны урсгалын хэмжээгээр тодорхойлогдох ба барилга байгууламжийн хийц болон архитектур-төлөвлөлтийн шийдлээс хамаарна. Тус уурхайн дулаанаар хангах барилга байгууламжийг бага оврын нам даралтын уурын зуухаар хангах боломжтой байна.

1.4.4. Усан хангамж

Уурхайн ажилчдын ундны усны хэрэглээг БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30- ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 12-р хавсралт “Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд холбогдоогүй орон сууц”-д 1 хүн 150 л/хон байна. Ногоон байгууламжийн усалгааг тус тушаалын 13-р хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д 1 м² талбайд 4 л, “Технологийн хэрэглээ буюу зам, талбайн усалгаа”-д 1 м² талбайд 2 л гэсэн нормыг тус тус баримталж ус хэрэглээний тооцоог хийж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 16. Усны хэрэглээ

Ашиглалтын жилүүд	Далд уурхайн усны хэрэглээ	Ил уурхайн усны хэрэглээ	Унд ахуйн усны хэрэглээ	Ногоон байгууламжийн усны хэрэглээ	Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ	Нийт
-------------------	----------------------------	--------------------------	-------------------------	------------------------------------	------------------------------------	------

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	м ³ /жил					
2026 он	-	1,262	540	50	-	1,852

Тооцоогоор 2026 оны ашиглалтын жил 1,852 м3 ус хэрэглэхээр байна.

1.7.Төслийн эцсийн бүтээгдэхүүн

1.5.1.Элементийн шинжилгээ, металлын баланс

Нэр- Хайлуур жоншны хүдэр


Марк- ХЖ-20-оос ХЖ-55 Олон

улсын нэршил- FO

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Физик газарзүй: “Хас рич” ХХК-ийн Өлзийт ухаа хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Чойр хотоос зүүн урагш 59 км зайд, байр зүйн зургийн L-49-62-Г хавтгайд MV- MV- 018971 тоот “Өлзийт ухаагийн” хайлуур жоншны орд оршино. Улаанбаатар хотоос 290 км хатуу хучилттай засмал замтай, төмөр замын 20-р зөрлөгөөс 400-500 м зайд байрладаг. Талбайн байршлын зураг болон талбайн солбилцлыг хүснэгт 1, зурагт 1-т тус тус үзүүлэв. Цаг уурын хуурай гандуу уур амьсгалтай бөгөөд нийт 500.01 га талбайг эзэлнэ. Талбайн дийлэнх хэсэг нь далайн төвшнөөс дээш 1179-1352 м өргөгдсөн, 20-50 м харьцангуй өндөржилттэй нам уулсын толгодорхог орой хэсгүүдтэй. Ордын талбай нь физик газарзүйн мужлалаар Говийн их мужид, гадаргуугийн хэлбэр шинжээр нь ухаа гүвээт талын хэв шинжид багтаан үздэг байна /Ш.Цэгмид, 1967 он/.



Зураг 2. Төслийн талбайн байгалийн бүс бүслүүрийн байдал

Уур амьсгал: Төв Монголын эрс тэс уур амьсгалтай, дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Хамгийн их халуун /300 ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаж хэм 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -20-15 байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг байдаг. Жилд дунджаар 205-350 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг. Төсөл хэрэгжих талбай орчмоор анхны цочир хүйтрэлт 9-р сарын 17-ны үед эхлэн, 5-р сарын 23-ны үед дуусна. Монгол орны хувьд агаарын температурын жилийн дундаж сүүлийн 30 орчим жил 1.9°C-аар дулаарсан бол өмнө ба зүүн бүсэд 1.5-1.6°C, баруун ба төвийн бүсэд 2.0 - 2.3°C- аар тус тус дулаарчээ. Дулааралт хүйтний улиралд илүү их ажиглагдаж байгаа бөгөөд өвлийн улиралд агаарын температурын дундаж 3.6°C, хавар намрын улиралд 1.4-1.9°C-аар нэмэгдсэн байна.

Усан орчин: Судалгааны талбай орчимд байнгын устай гадаргын ус байхгүй. Районы хэмжээнд хур тунадсаар тэжээгддэг хужир, мараалаг, давсархаг шал тойрмууд цөөн тоогоор бий. Ихэнх хур тунадас 7-8-р сард бороо хэлбэрээр орно. Түр зуурын урсац бүхий цөөн тооны гол дулааны улиралд хур багатай жил шургаж усгүй сайрууд болдог. Судалгааны талбай түүний дүүрэг нь усан хангамж сайтай, ус зүйн үүднээс Номхон далайн ай сав, Умард говийн гүвээт-Халхын говийн сав газарт тус тус багтана. Цөөн тооны булаг нь гадаргад хагарлын бүсээр хянагдсан булгуудаар тэжээгдэх бөгөөд зуны улиралд буух хур тунадасны хэмжээтэй шууд холбоотой байна. Талбайд хамгийн ойр байрлах бөгөөд харьцангуй ундарга сайтай худаг нь Өлзийт болон нэргүй худаг юм. Нэргүй худаг нь 190 л/цаг ундаргатай ба талбайгаас зүүн тийш 6 км-т байрлана.

Хөрсөн бүрхэвч: Судалгаанд хамрагдсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах “Хас рич” ХХК-ийн Өлзийт ухаагийн жоншны орд нь Монгол орны хөрс- газарзүйн мужлалаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн Баяндэлгэрийн тойрогт хамаарагдана /Монгол улсын үндэсний атлас, 2009/.

Судалгааны талбайд хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн, тал нам доор газраа цайвар шаргал, хужирлаг, өндөрлөг газраа улаан хүрэн, хүрэвтэр өнгийн хөрс ялгагдана. Цайвар хүрэн, бор хүрэн хөрс нь голдуу элсэнцэр, шавранцраас тогтох бол цайвар шаргал хөрс нь аллюви-нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хуурай уур амьсгалын нөхцөлд орчин үеийн хөрс үүсэх ба өгөршлийн үйл явцын эрч хүч сул, учир сэвсгэр хурдас чулуулгийн дээд хэсгийн харьцангуй нимгэн үеийг хамардаг. Хөрсөн дэх ус чийгийн нэвчилт гүн биш, ургамлын үндэсний массын дийлэнх нь хөрсний дээд давхаргуудад бөөгнөрсөн байдгаас үзэхэд орчин үеийн хөрсний зузаан хагас метрээс хэтрэхгүй байна. Хөрсний доод давхаргууд дахь карбонатын хуримтлалын аль нь орчин үеийн хөрс үүсэх үйл явцын үр дүнд бий болжээ.

Ургамлан бүрхэвч: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евразийн хээрийн их муж Дагуур-Монголын (Төв Азийн) дэд их муж, Говийн умард цөлөрхөг хээрийн мужийн Говийн умард-дорнодын дэд мужид хамаарна. Ерөнхийдөө төслийн энэхүү талбайд говийн Хялганат бэлчээрийн бүлгэмдэл зонхилно. Хайлуур жоншны талбайд Монгол өвс-Шавагт, Монгол өвс-Хазаарт бүлгэмдэлтэйгээс гадна сайраа дагаад Дэрс-Улалжит бүлгэмдэлтэй. Ургамлын зүйлийн хувьд тэжээлийн үнэт үет ургамлууд давамгайлан ургаж байна. Ховор болон нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн ургамлын төрөл зүйл бүртгэгдээгүй. Харин малын тэжээлийн үнэт ургамал болох крыловын Хялгана, говийн Хялгана, саман Ерхөг, гялгар Дэрс, зүүнгарын Хазаарөвс, нарийн навчит Харгана, агь Шарилж, цагаан Шарилж зэрэг ургамал ургаж байна. Бүлгэмдлүүд Монгол өвс-Шавагт 32%, Монгол өвс-Хазаарт 28%-ийн ургамлан бүрхэцтэй байна. Харин зурваслан орж ирэх Дэрс-Улалжит бүлгэмдэл 80% бүрхэцтэй.

Амьтны аймаг: Төслийн талбай орчим нь амьтдын амьдрах орчны олон зүйл амьтад оргонох нөхцөлтэй боловч мэр сэр л амьтад үзэгддэг. Тус нутагт мэрэгчдээс тарвага, зурам, туулай; махан идэштнээс үнэг, хярс, чоно, мануул; өвсөн тэжээлтнээс цагаан зээр; жигүүртэн шувуудаас элээ, хэрээ, бүргэд, тас, шаазгай, болжмор, чогчиго, ногтруу байдаг гэж тэмдэглэжээ. Хөхтөн амьтдын бүрэлдэхүүн: Хээрийн судалгааны хугацаанд төслийн талбайд цоохор хонин гүрвэл (*Phrynoscephalus versicolor*) элбэг тохиолдож байсан ба нутгийн иргэн говийн гүрвэл тохиолддог гэсэн боловч говийн гүрвэлийн төрөлд багтдаг говийн гүрвэл (*Eremias przewalskii*), могой гүрвэл (*Eremias multiocellata*), монгол гүрвэл (*Eremias argus*) хэмээх 3 зүйлийн нэг монгол гүрвэл юм. Учир нь монгол гүрвэл амьдрах дуртай биотоп болох чулуурхаг толгод, харгана энэ талбайд байлаа. Говийн гүрвэл амьдардаг биотоп тус талбайд байхгүй харин чулуурхаг толгодоор амьдардаг могой гүрвэл тохиолдох магадлалтай. Могойны салбар багаас 1 зүйл могой тохиолддог.

Даланжаргалан сумын нийгэм эдийн засаг: Даланжаргалан сум Ардын хувьсгалын ялалтын дараахан нутгийн захиргаадыг байгуулахад Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуунд харьяалагдаж байгаад 1924 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн V тогтоолоор

“Даланжаргалан сум” нэртэйгээр Боржигон Цэцэн вангийн хошууны нутаг "Элдэв" хэмээх газарт байгуулагдсан юм.

Сумын анхны даргаар Шар хэмээх Дашдэндэв сонгогдон ажиллажээ. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа Цомог хэмээх газарт суурьшсан байна.

